



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2022 | V



 www.facebook.com/StatisticBayangol

 www.ubstat.mn

 www.1212.mn

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН
САРЫН ТАНИЛЦУУЛГА

2022
5 сар

Улаанбаатар хот
2022 он

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- - гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрбум	=10 ⁹
их наяд	=10 ¹²
мян.	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас

АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	2
 НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР	3
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	6
 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	9
 ГЭМТ ХЭРЭГ	12
 ДҮҮРГИЙН ТӨСӨВ	16
 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	19
 АЖ ҮЙЛДВЭР	28
 ЦАГ УУР, АГААРЫН ОРЧИН	33

I-V/2022

Тархаасан: 2022 оны 6 дугаар сарын 20

ХҮСНЭГТ 1. БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 I-V	2020 I-V	2021 I-V	2022 I-V
Шинээр төрсөн хүүхэд	тоо	2 166 ^{↓2.1}	2 098 ^{↓3.1}	1 999 ^{↓4.7}	1 571 ^{↓21.4}
Амаржсан эхийн тоо	Тоо	2 138 ^{↓2.2}	2 067 ^{↓3.3}	1 991 ^{↓3.7}	1 553 ^{↓22.0}
Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст	Хүн	1 067 ^{↑13.0}	1 249 ^{↑17.1}	864 ^{↓30.8}	595 ^{↓31.1}
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	Тоо	1 223 ^{↓37.2}	708 ^{↓42.1}	7 603 ^{↑10.7}	22 890 ^{↑30.1¹}
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	1 897 ^{↓22.8}	1 438 ^{↓22.2}	956 ^{↓33.5}	2 319 ^{↑2.4¹}
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$=₮	2 648.9 ^{↑9.9}	2 806.8 ^{↑6.0}	2 849.2 ^{↑1.5}	3 110.2 ^{↑9.2}
Дүүргийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	41.5 ^{↑18.6}	46.3 ^{↑11.6}	47.3 ^{↑2.2}	41.7 ^{↓11.8}
Дүүргийн төсвийн зарлага	Тэрбум төгрөг	34.9 ^{↑17.9}	42.1 ^{↑20.6}	36.2 ^{↓14.0}	34.7 ^{↓4.1}

Тайлбар: өмнөх онтой харьцуулсан ^{↑, ↓} эерэг өөрчлөлтийн хувь;
^{↑, ↓} сөрөг өөрчлөлтийн хувь;
 = тогтвортой
¹-дахин их

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2021 I-V					2022 I-V				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	321	Баянгол	7 903	Налайх	57	329	Баянгол	8 055	Налайх	57
			Чингэлтэй	1 704	Багануур	48		Чингэлтэй	1 693	Багануур	48
			Сүхбаатар	697	Багахангай	32		Сүхбаатар	696	Багахангай	32
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	10	Налайх	24	Хан-Уул	5	13	Багахангай	31	Хан-Уул	8
			Багануур	12	Баянзүрх	5		Сонгинохайрхан	15	Баянгол	6
			Сонгинохайрхан	11	Багахангай	-		Налайх	12	Багануур	5
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	326	Хан-Уул	381	Налайх	251	999	Багахангай	2 436	Сүхбаатар	847
			Баянзүрх	353	Багануур	75		Налайх	2 035	Чингэлтэй	680
			Баянгол	333	Багахангай	46		Хан-Уул	1 245	Сонгинохайрхан	599
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	98	Чингэлтэй	132	Багануур	14	114	Баянзүрх	210	Сонгинохайрхан	95
			Хан-Уул	69	Налайх	12		Хан-Уул	144	Налайх	65
			Сүхбаатар	67	Багахангай	11		Баянгол	119	Багахангай	26
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	61	Сүхбаатар	86	Налайх	37	119	Сүхбаатар	158	Налайх	65
			Хан-Уул	67	Багахангай	37		Баянгол	150	Багануур	46
			Баянзүрх	64	Багануур	29		Чингэлтэй	134	Багахангай	40




Ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 595 болж, өмнөх оны мөн үеэс 31.1 нэгж хувиар буурлаа

Дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр тус хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2022 оны 5 дугаар сард 595 болж, өмнөх оны мөн үеэс 269 хүнээр (31.1%) буурсан байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 290 нь (48.7%) эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны ангилалаар, жил бүрийн 5 дугаар сарын сард

Үзүүлэлт	2021 V		2022 V	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Өмнөх сарын эцэст байсан ажилгүйчүүд	1 097	618	674	332
Тухайн сард нэмэгдсэн ажилгүйчүүд	251	126	214	109
Тухайн сард бүртгэлээс хасагдсан	484	-	293	-
Үүнээс: Ажилд зуучлагдсан	55	-	56	-
Тухайн сарын эцэст байгаа ажил хайгч иргэн	864	483	595	290
Үүнээс: Насны ангиллаар				
15-24	39	19	32	18
25-34	296	151	222	108
35-44	288	175	196	96
45-54	182	116	119	58
55-59	55	21	21	8
60+	4	1	5	2

ЗУРАГ 1. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2022 оны 5 дугаар сард



Бүртгэлтэй нийт ажил хайгч иргэний 32 нь (5.4%) 15-24 насны, 222 нь (37.3%) 25-34 насны, 196 нь (33.0%) 35-44 насны, 119 нь (20.0%) 45-54 насны, 21 нь (3.5%) 55-59 насны, 5 нь (0.8%) 60-аас дээш насны хүмүүс байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 27 нь (4.5%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд бөгөөд үүнээс 14 нь (51.8%) эмэгтэйчүүд байна.

Дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн хөдөлмөр эрхлэлтийн албанд 2022 оны 5 дугаар сард 214 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 56 иргэн ажилд зуучлагдан орж, 293 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

ЗУРАГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН, АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн 5 дугаар сард



2021 – V	251	55
2022 – V	214	56

Шинээр бүртгүүлсэн
ажилгүй иргэд



Ажилд зуучлагдан
орсон иргэд



2022 оны 5 дугаар сард 214 ажилгүй иргэн шинээр бүртгүүлснээс 17 нь (8.0%) сургууль төгсөөд ажилгүй байгаа, 11 нь (5.1%) шилжин суурьшсан, 180 нь (84.1%) ажлаас чөлөөлөгдсөн буюу халагдсан, үлдсэн 6 нь (2.8%) бусад шалтгаанаар ажил хайж байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63.7 хувиар, ажилд зуучлагдан орсон иргэд 74.8 хувиар тус тус буурчээ.

ЗУРАГ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙГ, боловсролын түвшнээр, дүнд эзлэх хувиар, 2022 оны 5 дугаар сард



167 (28.1%)
Бүрэн дунд

7 (1.2%)
Магистр,
Доктор

348 (58.5%)
Дипломын болон
бакалаврын дээд

25 (4.2%)
Техникийн болон
мэргэжлийн анхан шат

45 (7.5%)
Тусгай
мэргэжлийн
дунд

3 (0.5%)
Суурь



2022 оны 05 сарын эцэст бүртгэлтэй байгаа ажил хайгч иргэдийн 28.1 хувийг бүрэн дунд, 58.5 хувийг дипломын болон бакалаврын дээд, 7.5 хувийг тусгай мэргэжлийн дунд, 4.2 хувийг техникийн болон мэргэжлийн анхан шат, 1.2 хувийг магистр, доктор, 0.5 хувийг суурь боловсролтой иргэд тус тус эзэлж байна. Бага боловсролтой болон боловсролгүй иргэд ажил хайгч иргэнээр бүртгүүлээгүй байна.

Ойлголт, тодорхойлолт:

Ажилгүй хүн: Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм (заалт 47 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

Ажил хайж байгаа: Сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм. Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно. Харин ажлын байрны талаар мэдээлэл авсан ч ажил олгогчид хандаагүй бол идэвхтэй оролдлого хийсэн гэж үзэхгүй.

Эх үүсвэр: Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн сарын мэдээ



Нийгмийн даатгалын орлого өмнөх оны мөн үеэс 88.8 хувиар, нийгмийн даатгалын зарлага 21.2 хувиар тус тус өсжээ


2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын 5 төрлийн санд нийт 160.0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 75.3 (88.8%) тэрбум төгрөгөөр өсжээ.

ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2021 I-V	2022 I-V	<u>2022 I-V</u> 2021 I-V
	сая төгрөг		хувь
Нийт орлого	84 728.4	160 012.6	188.8
Тэтгэврийн даатгалын сангийн	76 968.1	110 631.7	143.7
Тэтгэмжийн даатгалын сангийн	3 537.2	12 690.3	358.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	-	22 343.9	-
ҮОМШӨ ² -ний даатгалын сангийн	3 546.3	10 784.9	304.1
Ажилгүйдлийн даатгалын сангийн	676.8	3 561.8	526.3
Нийт зарлага	83 854.2	101 648.3	121.2
Тэтгэврийн даатгалын сангийн	71 830.5	89 910.2	125.2
Тэтгэмжийн даатгалын сангийн	8 215.7	7 754.4	94.4
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	574.0	671.3	117.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	3 234.0	3 312.4	102.4

²Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

ЗУРАГ 4. ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, дүнд эзлэх хувиар, 2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар



Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 69.1 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 6.7 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 7.9 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 2.3 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд, эрүүл мэндийн даатгалын санд 14.0 хувь нь тус тус төвлөрчээ.

ЗУРАГ 5. ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, дүнд эзлэх хувиар, 2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар



Нийгмийн даатгалын сангаас 2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар даатгуулагч иргэдэд 101.6 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд зарцуулжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.8 (21.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт зардлын 88.5 хувийг тэтгэврийн, 0.7 хувийг ҮОМШӨ-ний, 7.6 хувийг тэтгэмжийн, 3.2 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГУУДЫН ЗАРЛАГА, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	Тэтгэвэр, тэтгэмж авагчид			Олгосон тэтгэвэр, тэтгэмж		
	2021 I-V	2022 I-V	<u>2022 I-V</u> <u>2021 I-V</u>	2021 I-V	2022 I-V	<u>2022 I-V</u> <u>2021 I-V</u>
	тоо			сая төгрөг		
НД-ын сангийн нийт зарлага	39 758	45 439	114.3	83 853.9	101 648.3	121.2
Тэтгэврийн даатгалын сан	29 592	30 817	104.1	71 830.4	89 910.2	125.2
Өндөр насны	22 839	23 936	104.8	57 211.5	73 524.5	128.5
Тахир дутуугийн	4 020	4 093	101.8	6 733.3	7 665.4	113.8
Тэжээгчээ алдсаны	1 036	1 061	102.4	1 756.0	2 103.3	119.8
Цэргийн тэтгэвэр	1 697	1 727	101.8	6 129.6	6 617.0	108.0
Тэтгэмжийн даатгалын сан	8 568	13 126	153.2	8 215.6	7 754.4	94.4
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	4 972	10 594	213.1	1 180.5	1 970.5	166.9
Жирэмсэн, амаржсаны тэтгэмж	3 562	2 502	70.2	7 002.1	5 754.9	82.2
Оршуулгын тэтгэмж	34	30	88.2	33.0	29.0	87.8
ҮОМШӨ*-ний даатгалын сан	234	236	100.8	574.0	671.3	117.0
Тахир дутуугийн тэтгэмж	173	171	98.8	465.1	548.1	117.8
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	25	22	88.0	82.2	78.4	95.4
Тэтгэмж, төлбөр	35	40	114.3	26.3	42.7	162.4
ҮОМШӨ*-ний сувилал	1	3	300.0	0.4	2.1	525.0
Ажилгүйдлийн даатгалын сан	1 364	1 260	92.4	3 234.0	3 312.4	102.4
Ажилгүйдлийн тэтгэмж	1 364	1 260	92.4	3 234.0	3 312.4	102.4

²Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Оны эхний 5 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас 45439 хүнд 101648.3 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгогдсоны 30817 хүнд 89910.2 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас, 13126 хүнд 7754.4 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын сангаас, 1260 хүнд 3312.4 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас, 236 хүнд 671.3 сая төгрөгийг үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тус тус зарцуулсан байна.

2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 30817 хүнд 89.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгогдсоны 81.8 хувийг өндөр настны, 8.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.3 хувийг тэжээгчээ алдсаны, 7.4 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна. Тэтгэвэр авагчийн 77.7 хувийг өндөр настны тэтгэвэр эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1097 (4.8%) хүнээр, 16.3 (28.5%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өнгөрсөн оны мөн үеэс нийт тэтгэмж авагчийн тоо 4558 (53.2%) хүнээр өсөж, олгосон тэтгэмжийн хэмжээ 461.2 (5.6%) сая төгрөгөөр буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Эх үүсвэр:

Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн сарын мэдээ



Нийт мэндэлсэн хүүхэд 1571 болж, өнгөрсөн оны мөн үеэс 22.0 хувиар буурсан байна

2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар 1553 эх амаржиж, 1571 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 438 (22.0%), мэндэлсэн хүүхэд өмнөх оны мөн үеэс 428 (21.4%) хүүхдээр тус тус буурсан байна.

Амьгүй төрөлтийн 10 тохиолдол бүртгэгджээ. Нийт амаржсан эхчүүдийн 5 (0.3%) нь гэртээ төрсөн байна.

ХҮСНЭГТ 6. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2020 I-V	2021 I-V	2022 I-V	<u>2022 I-V</u> 2021 I-V
	тоо			хувь
Амаржсан эхийн тоо	2 067	1 991	1 553	78.0
Амьд төрсөн хүүхэд	2 098	1 999	1 571	78.6
Нас барсан хүн	362	427	415	97.2
Эхийн эндэгдэл	-	1	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	19	17	10	58.8
1-5 настай хүүхдийн эндэгдэл	2	1	3	3.0 ¹
Амьгүй төрөлт	4	13	10	76.9
Гэрийн төрөлт	2	3	5	166.7
Хяналтгүй төрөлт	1	-	6	-

¹-дахин


0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 13 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 27.8 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Дүүргийн хэмжээнд нас баралт 415 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 12 (2.8%) хүнээр буурчээ.

Халдварт өвчин

Тус дүүрэгт 2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар халдварт өвчин 22890 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15287 (3.0 дахин) тохиолдлоор өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 6. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



Нийт халдварт өвчний дийлэнх буюу 97.9 хувийг цочмог халдварт өвчин буюу коронавируст халдвар Ковид-19 өвчлөл эзэлж байна. Халдварт өвчний тохилдол нэмэгдэх шалтгаан нь коронавирусын халдвар Ковид-19 өвчлөлтэй холбоотой.

Цочмог халдварт өвчний 99.5 хувийг коронавирусийн халдварт Ковид-19, үлдсэн 0.5 хувийг цусан суулга, улаан эсэргэнэ, гепатит, салхин цэцэг, гахай хавдар, сальмонеллөз, энтервирүст цэврүүт фарингит өвчин эзлээд байна.

ХҮСНЭГТ 7. ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2020 I-V	2021 I-V	2022 I-V	<u>2022 I-V</u> 2021 I-V
	тоо			хувь
Халдварт өвчин бүгд	708	7 603	22 890	3.0¹
Цочмог халдварт өвчин	263	7 227	22 517	3.1¹
Цусан суулга	65	-	27	-
Улаан эсэргэнэ	15	1	1	0.0
Менингококкт халдвар	-	-	-	-
Гепатит	15	4	3	75.0
Салхин цэцэг	116	-	53	-
Гахай хавдар	4	-	1	-
Сальмонеллөз	10	-	6	-
Бруцеллөз	1	-	-	-
Хүнсний гаралтай бактерт хордлого	3	-	-	-
Ёлом	2	-	-	-
Нярайн халдвар	-	-	-	-
Гар хөл амны өвчин	-	-	-	-
Улаанууд	-	-	-	-
Энтервирүст цэврүүт фарингит	11	-	14	-
Эритема	1	-	-	-
Аскариаз	-	-	-	-
Энтеробиоз	-	-	-	-
Энтеровирүст халдвар тодорхойгүй	-	-	-	-
Арьсны халдварт өвчин (exanthema subitum)	-	-	-	-
Хачигт рикетикоз	3	-	-	-
Ковид-19	17	7 222	22 412	3.1¹
БЗХӨ бүгд	316	276	299	108.3
Тэмбүү	214	203	204	100.5
Төрөлхийн тэмбүү	-	-	-	-
Заг хүйтэн	61	32	45	140.6
Трихомониаз	41	41	49	119.5
Мөөгөнцөр	-	-	1	-
Шинээр илэрсэн сүрьеэ	129	100	74	74.0

¹-дахин, Өмнөх оны мөн үетэй харьцуулбал Ковид-19-ийн халдвар хэт их өссөн

10.0 мянган хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 995 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 662.1 продицимилээр өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн оны мөн үеэс тэмбүү өвчин 1 (0.5%), заг хүйтэн өвчин 13 (40.6%), трихомониаз өвчин 8 (19.5%) тохиолдлоор тус тус өссөн сөрөг үзүүлэлттэй бол сүрьеэ өвчин 26 (26.0%), тохиолдлоор буурсан эерэг үзүүлэлттэй байна. 10.0 мянган хүн тутмын 9 нь тэмбүү, 2 нь заг хүйтэн, трихомониаз өвчнөөр өвчилж байна.

Мөн энэ хугацаанд Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлэгт 2780 иргэн хэвтэн эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 473 (26.7%) хүнээр өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Амьгүй төрөлт: Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойших хугацаанд, 500 граммаас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нь ч (зүрхний цохилт, судасны лугшилт, булчингийн хөдөлгөөн) илрэхгүй байгааг хэлнэ.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд нийт төрсөн хүүхдийн тоог амьгүй төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эх үүсвэр:

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын сарын мэдээ



Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 2319 (2.4 дахин) хэргээр өссөн байна

2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт 2319 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1363 хэргээр (2.4 дахин) өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 56.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар өсжээ.

Өнгөрсөн оны мөн үеэс дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг 2.4 дахин өссөн сөрөг үзүүлэлтэд залилангийн гэмт хэрэг 733-аар (2.6 дахин), хулгайн хэрэг 266-аар (2.6 дахин), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 27-оор (2.8 дахин), бусад гэмт хэрэг 129-өөр (2.3 дахин), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 174-өөр (2.0 дахин) тус тус өссөн нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар

Төрөл		2020 I-V	2021 I-V	2022 I-V	<u>2022 I-V</u> 2021 I-V
		тоо			хувь
Нийт гэмт хэрэг		1 438	956	2 319	2.4¹
Гэмт хэргийн төрөл	Хүнийг алах	6	3	6	2.0 ¹
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	14	6	10	166.7
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	300	176	350	2.0 ¹
	Хүчиндэх	14	7	19	2.7 ¹
	Хулгайлах	347	169	435	2.6 ¹
	Дээрэмдэх	41	19	34	179.0
	Залилах	523	459	1192	2.6 ¹
	ХАБТХАЖЭ ²	17	15	42	2.8 ¹
	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	1	-	-	-
	Булаалт	-	-	-	-
	Бусад	175	102	231	2.3 ¹

¹-дахин

²-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Бүртгэгдсэн гэмт хэргийн 18.8 хувийг хулгайн, 15.1 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 51.4 хувийг залилах, 1.5 хувийг дээрэмдэх, 0.4 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 1.8 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, 0.8 хувийг хүчиндэх, 0.2 хувийг хүнийг алах, 10.0 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Нийт гэмт хэргийн дийлэнх буюу 51.4 хувийг залилангийн гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 733 хэргээр (2.6 дахин) өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 2200 (94.9%) нь хөнгөн хэрэг, 119 (5.1%) нь хүнд хэрэг байна.

Нийт бүртгэгдсэн 2319 гэмт хэргээс 1362 нь (58.7%) цагдаагийн I хэлтэст, 957 нь (41.3%) цагдаагийн II хэлтэст бүртгэгдсэн байна.


ХҮСНЭГТ 9. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, хэлтсээр, 2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар

Төрөл		Бүгд	Үүнээс:	
			Цагдаагийн I хэлтэс	Цагдаагийн II хэлтэс
		тоо		
Нийт гэмт хэрэг		2 319	1 362	957
Хэргийн ангилал	Хөнгөн	2 200	1 309	891
	Хүнд	119	53	66
Гэмт хэргийн төрөл	Хүнийг алах	6	2	4
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	10	5	5
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	350	198	152
	Хүчиндэх	19	9	10
	Хулгайлах	435	248	187
	Дээрэмдэх	34	16	18
	Залилах	1192	760	432
	ХАБТХАЖЭ ²	42	24	18
	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	-	-	-
	Бусад	231	100	131

²Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 296 (12.8%) гэмт хэрэг гарсан нь хамгийн их байсан бол, хамгийн бага нь 21, 25 дугаар хороодод үйлдэгдээд байна.

ЗУРАГ 7. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар



ХҮСНЭГТ 10. НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, хороо, төрлөөр, 2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар

Хороо	Нийт	Хүн амь	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	Хүчин	Хулгай	Дээрэм	Залилан	ХАБТХАЖЭ ²	Бусад	Танхайрах
Бүгд	2 319	6	10	350	19	435	34	1 192	42	231	-
I хороо	81	-	-	7	1	12	1	53	2	5	-
II хороо	169	-	-	12	-	32	1	106	3	15	-
III хороо	155	-	-	22	-	22	-	87	4	20	-
IV хороо	296	-	-	15	2	16	1	241	3	18	-
V хороо	80	-	-	11	-	26	2	19	3	19	-
VI хороо	73	-	-	23	1	11	2	20	3	13	-
VII хороо	141	-	1	21	2	19	4	75	2	17	-
VIII хороо	64	1	-	16	1	17	3	13	2	11	-
IX хороо	47	-	-	20	1	12	1	6	2	5	-
X хороо	25	1	-	4	-	11	-	7	1	1	-
XI хороо	98	-	1	11	-	18	2	48	5	13	-
XII хороо	82	-	3	13	-	21	2	40	0	3	-
XIII хороо	49	-	-	8	1	19	2	8	0	11	-
XIV хороо	121	-	-	20	-	34	2	58	1	6	-
XV хороо	71	-	-	4	1	13	-	50	1	2	-
XVI хороо	118	1	-	24	-	31	1	54	1	6	-
XVII хороо	130	-	1	26	2	14	1	72	1	13	-
XVIII хороо	111	-	-	20	3	11	2	63	2	10	-
XIX хороо	82	-	-	14	-	16	1	49	1	1	-
XX хороо	139	2	3	25	1	36	2	35	2	33	-
XXI хороо	20	-	1	5	-	11	1	1	0	1	-
XXII хороо	61	-	-	16	1	8	3	30	1	2	-
XXIII хороо	35	1	-	2	1	6	-	24	1	0	-
XXIV хороо	48	-	-	7	-	10	-	26	1	4	-
XXV хороо	23	-	-	4	1	9	-	7	0	2	-

²Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Хороодод гарсан гэмт хэргийн өсөлт, бууралтыг харвал өмнөх оны мөн үеэс 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт 16.9 хувиар, 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 13.0 хувиар, 25 дугаар хорооны нутаг дэвсгэрт 4.1 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй, харин бусад хороодод 16.0 хувиас 6.1 дахин өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16. түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр:

Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын мэдээ



Дүүргийн төсвийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 22.6 хувиар буурчээ

Дүүргийн төсвийн нийт орлого 2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар 41720.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 25611.3 (38%) сая төгрөгөөр дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 96.7 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 3.3 хувийг татварын бус орлого тус тус эзэлж байна.

Татварын орлогын дүнд хувь хүний орлогын албан татварын шилжүүлэг хамгийн өндөр буюу 32830.6 (81.4%) сая төгрөгийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 11. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар


Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
	сая төгрөг		хувь
Нийт орлого	67 331.5	41 720.2	62.0
1.Татварын орлого	65 764.3	40 325.4	61.3
1.1 Орлогын албан татвар	56 807.8	32 830.6	57.8
Хувь хүний орлогын албан татвар	56 807.8	32 830.6	57.8
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон	44 912.8	21 485.2	47.8
Үйл ажиллагааны орлого	920.6	686.0	74.5
Хөрөнгийн орлого	4 529.9	2 916.4	64.4
Хөрөнгө борлуулсны орлого	3 507.2	3 775.2	107.6
Шууд бус орлого	2 937.3	3 967.8	135.1
1.2 Хөрөнгийн татвар	3 907.9	2 986.6	76.4
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	3 880.3	2 962.2	76.3
Бууны албан татвар	27.6	23.9	86.6
Малд ногдуулах албан татвар	-	0.5	-
1.3 Бусад татвар, төлбөр, хураамж	5 048.6	4 508.2	89.3
Бусад нийтлэг татвар, төлбөр, хураамж	1 471.4	1 435.8	97.6
Улсын тэмдэгтийн хураамж	438.4	481.7	109.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1 033.0	954.1	92.4
Газрын төлбөр	3 577.2	3 069.2	85.8
Ус, рашаан нөөц ашигласны төлбөр	-	3.2	-
2. Татварын бус орлого	1 567.2	1 394.8	89.0
2.1 Нийтлэг татварын бус орлого	1 066.9	922.3	86.4
Торгуулийн орлого	944.7	765.5	81.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/	112.1	145.6	129.9
Төсөвт байгууллагын өөрийн орлого /туслах/	10.1	11.0	108.9
Бусад орлого	-	0.2	-
2.2 Улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	500.3	472.5	94.4
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	500.3	472.5	94.4

ХҮСНЭГТ 12. ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
	сая төгрөг		хувь
Нийт зарлага	72 756.6	34 732.0	47.7
Урсгал зардал	67 331.6	32 905.1	48.9
Бараа, ажил үйлчилгээний зардал	16 780.9	13 467.2	80.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6 250.9	5 300.4	84.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	859.1	680.3	79.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2 642.8	2 060.3	78.0
Хангамж бараа материалын зардал	1 569.0	1 384.5	88.2
Нормативт зардал	10.4	5.6	53.8
Эд хогшил, урсгал засварын зардал	505.4	194.6	38.5
Томилолт, зочны зардал	134.1	60.3	45.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	1 942.1	1 459.2	75.1
Бараа үйлчилгээний бусад зардал	2 867.1	2 322.0	81.0
Урсгал шилжүүлэг	50 550.7	19 437.9	38.5
Хөрөнгийн зардал	5 425.0	1 826.9	33.7

Дүүргийн төсвийн нийт зарлага 2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар 34732 сая төгрөг болж, төлөвлөснөөс 38024.6 (52.3%) сая төгрөгийг зарцуулсан байна. Төсвийн нийт зарлагын дүнд хамгийн өндөр нь урсгал зардал байна.

ЗУРАГ 8. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөгөөр, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар



Дүүргийн төсвийн нийт орлого, зарлагыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 11.7 хувиар, зарлага 4.2 хувиар буурчээ.

ХҮСНЭГТ 13. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН НИЙТ ӨГЛӨГ, АВЛАГЫН МЭДЭЭ, 2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	V сарын эхний үлдэгдэл	Нэмэгдсэн: тухайн сард үүссэн өглөг	Хасагдсан: тухайн сард төлөгдсөн өглөг	V сарын эцсийн үлдэгдэл	Дүнд эзлэх хувь
	мянган төгрөг				
НИЙТ ӨГЛӨГ	171 970.3	18 574.8	112 312.3	78 232.8	100.0
Үндсэн цалин	20 397.9	554.8	18 519.2	2 433.4	3.1
Нийгмийн даатгалын шимтгэл	28 396.7	1 927.8	17 674.2	12 650.3	16.2
Гэрэл, цахилгаан	10 024.2	3 929.8	8 363.5	5 590.6	7.1
Түлш, халаалт	86 694.7	1 188.0	61 786.2	26 096.5	33.3
Цэвэр, бохир ус	25 614.3	4 617.3	15 093.4	15 138.2	19.4
Бичиг хэрэг	170.4	-	-	170.4	0.2
Шуудан, холбоо, интернет	672.1	5 481.3	-	6153.4	7.9
Бараа үйлчилгээний бусад зардал	-	10 000.0	-	10 000.0	12.8

2022 оны эхний 5 дугаар сард 78232.8 мянган төгрөгний өглөг үүсч, үүний дийлэнх буюу 33.3 хувийг түлш халаалт, 26.5 хувийг гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, 19.3 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл, 8.1 хувийг бичиг хэрэг, шуудан, холбоо, интернет, үлдсэн 12.8 хувийг бараа үйлчилгээний бусад өглөг тус тус эзлэж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Эх үүсвэр:


Баянгол дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар өслөө

2022 оны 5 дугаар сарын хэрэглээний үнийн индекс 2021 оны жилийн эцэстэй харьцуулахад 8.7 хувь, өмнөх сартай харьцуулахад 1.4 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 9. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, сараар



Хэрэглээний үнийн индекс 2022 оны 5 дугаар сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 8.7 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 11.9 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 3.3 хувь, хувцас, бөс бараа, гутал бүлгийн үнэ 9.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 12.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 9.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 13.3 хувь, тээврийн бүлгийн үнэ 5.9 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 1.9 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 2.4 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 4.5 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 9.4 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 14. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр, 2022 оны 4 дүгээр сард


Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2021-V</u> <u>2020-V</u>	<u>2022-V</u> <u>2021-V</u>	<u>2022-V</u> <u>2021-XII</u>	<u>2022-V</u> <u>2022-IV</u>
Ерөнхий индекс	106.7	116.2	108.7	101.4
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	113.2	119.0	111.9	102.9
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	102.5	109.6	103.3	100.7
Хувцас, бөс бараа, гутал	101.5	114.7	109.3	100.8
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	106.3	110.7	112.9	98.3
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	102.8	114.8	109.1	101.8
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	105.2	118.9	113.3	100.9
Тээвэр	105.3	126.0	105.9	101.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.3	105.6	101.9	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	101.2	104.5	102.4	101.2
Боловсролын үйлчилгээ	101.4	105.9	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	110.2	118.3	104.5	103.5
Бусад бараа, үйлчилгээ	106.3	119.3	109.4	101.5

2022 оны 5 дугаар сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 41.87 хувийнх нь үнэ өсөж, 2.03 хувийнх нь үнэ буурч, 56.1 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.


ХҮСНЭГТ 15. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН САРЫН ИНДЕКС, /**аерэг**, **сөрөг**/

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	2.9	Энэ бүлгийн үнийн өсөлтөд бүх төрлийн кофе, цай, какао бүтээгдэхүүний үнэ 28.9 хувиар, хүнсний ногооны үнэ 6.4 хувиар, загас, далайн бүтээгдэхүүний үнэ 5.2 хувиар, төрөл бүрийн өөх, тосны үнэ 3.8 хувиар, саахар, жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколадны үнэ 2.9 хувиар тус тус голлон нөлөөлөв.
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	0.7	Энэ бүлгийн үнийн өсөлтөд дарсны үнэ 3.2 хувиар, шар айргийн үнэ 0.7 хувиар тус тус шууд нөлөөлөв.
Хувцас, бөс бараа, гутал	0.8	Энэ бүлгийн үнийн өсөлтөд хувцас засвар, цэвэрлэгээ, түрээсийн үнэ 2.4 хувиар, гутал засвар, түрээсийн үнэ 9.0 хувиар тус тус голлон нөлөөлөв.
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	1.7	Энэ бүлгийн үнийн бууралтад хатуу түлшний үнэ 6.0 хувиар буурсан нь нөлөөлөв.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	1.8	Энэ бүлгийн үнийн өсөлтөд гэр ахуйн жижиг цахилгаан хэрэгслийн үнэ 9.6 хувиар, гэр ахуйн барааны үнэ 2.7 хувиар, жижиг багаж хэрэгслийн үнэ 1.8 хувиар тус тус нөлөөлөв.
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.9	Энэ бүлгийн үнийн өсөлтөд шүдний эмнэлгийн үйлчилгээний үнэ 7.0 хувиар, эрүүл мэндийн бусад барааны үнэ 1.5 хувиар тус тус шууд нөлөөлөв.
Тээвэр	1.4	Энэ бүлгийн үнийн өсөлтөд хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний үнэ 2.6 хувиар шууд нөлөөлөв.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	1.2	Энэ бүлгийн үнийн өсөлтөд чөлөөт цаг, соёлын үйлчилгээний үнэ 9.9 хувиар, бичгийн болон зургийн хэрэгслийн үнэ 6.6 хувиар, чөлөөт цагт зориулсан бусад хэрэгслийн үнэ 5.1 хувиар тус тус голлон нөлөөлжээ.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.5	Энэ бүлгийн үнийн өсөлтөд ресторан, кафе, бусад зоогийн газрын үйлчилгээний үнэ 4.6 хувиар, гуанз, цайны газрын үйлчилгээний үнэ 2.7 хувиар тус тус шууд нөлөөлөв.
Бусад бараа, үйлчилгээ	1.5	Энэ бүлгийн үнийн өсөлтөд гоо сайхны хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлсийн үнэ 1.5 хувиар голлон нөлөөлжээ.


ЗУРАГ 10. НЭГ ШИРХЭГ ТАЛХНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн 5 дугаар сард




ЗУРАГ 11. НЭГ КИЛОГРАММ САВЛАСАН ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн 5 дугаар сард



ЗУРАГ 12. НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн 5 дугаар сард



ЗУРАГ 13. НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн 5 дугаар сард




2022 оны 5 дугаар сард хүнсний зах, супермаркет, бөөний төвүүдэд жижиглэн худалдаалагдаж буй хонины ястай махны үнэ өмнөх сартай харьцуулахад 0.7 хувиар, үхрийн ястай мах 4.2 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 16. НЭГ КИЛОГРАММ МАХНЫ ЖИЖИГЛЭН ХУДАЛДАХ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, сараар


Үхрийн ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845	8 005	8 305
2019	8 875	8 925	9 390	9 635	10 960	11 700	12 280	11 540	11 375	10 950	10 090	9 755
2020	10 535	11 415	11 665	11 735	11 940	12 640	12 760	11 760	11 235	10 855	11 075	11 210
2021	11 615	12 605	12 670	13 850	13 960	14 770	14 800	13 700	13 420	13 280	13 345	13 495
2022	14 060	14 235	14 260	14 530	15 140							

Хонины ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440	6 690	6 695
2019	7 170	7 340	7 945	8 710	9 820	10 430	10 045	9 700	9 640	9 095	7 710	7 635
2020	8 705	9 600	9 765	9 835	10 125	10 385	10 650	9 870	9 170	8 715	8 635	8 580
2021	9 040	10 460	10 705	12 320	12 390	12 695	12 440	11 380	10 975	11 005	10 775	10 805
